



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/08

Хэрлэн сум

Ажлын цагийн хуваарьт өөрчлөлт  
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчлөлийн дэгдэлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 215 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчлөл улсын хэмжээнд нэмэгдэж байгаатай холбогдуулан өвчний дэгдэлтийг таслан зогсоох, иргэдийг өвчлөхөөс сэргийлэх зорилгоор өрхийн эрүүл мэндийн төвийг 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрөөс мөн оны 3 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Бямба гараг бүрт ажиллуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн газрын дарга Ц.Гэрэлмаа, Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч Ц.Идэрбат, Бор-Өндөр сумын Засаг дарга П.Чинбат нарт тус тус үүрэг болгосугай.

Хоёр. 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрөөс мөн оны 3 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 5 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээрээ 3-5 хоног асарсан ажил, хөдөлмөр эрхэлж байгаа эх, эцэг, асран хамгаалагчид цалинтай чөлөө олгохыг ажил олгогч нарт даалгасугай.

Гурав. Дээрх арга хэмжээний талаар 14 хоног тутам мэдээллээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Гэрэлмаа/-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 032